Golomt Capital®

Таваарын зах зээлийн долоо хоногийн тойм

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.01.17

Нүүрс
Төмрийн хүдэр
Зэс

НҮҮРСНИЙ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 01-р сарын 17

Долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрсөн долоо хоногийн лхагва гарагт Индонез улс 37 нүүрс тээвэрлэгч хөлөг онгоцыг экспортоор гаргахаар болсон байна. Салбарын яамны сайдын мэдэгдэж байгаагаар нүүрс олборлогчдийн олборлолт болон нийлүүлэлт сэргэж 15 хоногийн нүүрсний нөөц бүрдээд байгаатай холбоотой 1 сарын 1 өдөр хэргэжүүлсэн нүүрсний экспортын хориг цаашид сулрах төлөвтэй байгааг мэдэгдсэн.

Reuters-ийн мэдээллээр эрчим хүчний яамнаас 37 нүүрс тээвэрлэгч хөлөг онгоцны 18-д нь нүүрс экспортын зөвшөөрлийг өгөөд байгаа бөгөөд нийтдээ 1.3 сая тонны нүүрс тээвэрлэж байгаа юм байна. Харин үлдсэн хөлөг онгоцууд экспорт хийх хүсэлтээ өгсөн байгаа бөгөөд хүлээлгийн төлөвтэй энэ долоо хоногт гаалиар гарах төлөвтэй байна.

Индонез улсын нүүрсний экспортын хориг нь тус улсын Perusahaan Listrik Negara төрийн өмчит эрчим хүчний компанийн нүүрсний нөөц багасаж улс орон даяар цахилгаангүй болох нөхцөл байдал үүссэнтэй холбоотой экспортын хоригийг хэргэжүүлсэн. Индонезийн холбогдох яамны удирдлагууд нүүрсний нийлүүлэлтийн хомсдолыг нүүрс олборлогчид олборлолтын төлөвлөгөөгөө биелүүлж чадаагүйтэй холбоотой үүссэн хэмээн тайлбарлаад байгаа.

Өнгөрсөн долоо хоногт БНХАУ-ын Zhengzhou таваарын биржид дулааны нүүрсний ханш 660 юань дээр нээгдэж баасан гарагт 722 юань дээр хаагдсанаар ханш 9 хувиар өссөн байна. Индонез улсын нүүрсний нийлүүлэлт хангалттай байж чадахгүй байгаа ч БНХАУ дахь нүүрсний агуулхын нөөц хангалттай байгаа буюу 30 хоногт хүрэлцэхүйц хэмжээний нөөцтэй байгаа нь ханшийг өндөр савлуулахгүй байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Golomt Capital®

ТӨМРИЙН ХҮДРИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 01-р сарын 17

Долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрсөн долоо хоногийн даваа гарагт БНХАУ-ын Далианы таваарын биржид арилжаалагдаж буй төмрийн хүдрийн 5 сарын гэрээний ханш 717 юань дээр нээгдэж баасан гарагт 722 юань дээр хаагдсанаар 0.6 хувийн өсөлт үзүүллээ.

Creditsight-ийн тайланд дурдсанаар БНХАУ нь урт хугацааны агаарын бохирдлыг бууруулах төлөвлөгөөтэй байгаатай холбоотой Бээжингийн өвлийн олимпын дараагаар гангийн үйлдвэрлэлийг сэргээх эсэх нь эргэлзээтэй байгааг мэдэгдсэн байна.

Moody's агентлагийн мэдэгдэж байгаагаар 2022 онд төмрийн хүдрийн ханш тонн нь 100 гаруй ам.доллар дээр хэлбэлзэх төлөвтэй байгаа бөгөөд энэ нь 2021 оны ханшийн түвшингээс багаар таамаглагдсан байгаа хэдий ч түүхэн түвшинтэйгээ харьцуулахад харьцангуй эерэгээр таамаглагдсан байгаа юм байна. 2022 онд ханш 2021 оноос бага байх гол үндэслэл нь БНХАУ-ын агаарын бохирдлыг бууруулах бодлого, үл хөдлөх хөрөнгө барилгын салбарын идэвхи бага байгаа зэрэг нь ган үйлдвэрлэгчдийн идэвхийг бууруулах төлөвтэй байгаатай холбоотой юм байна.

БНХАУ-ын Гаалийн ерөнхий газрын мэдээллээр 2020 онд БНХАУ 1.17 тэрбум тонн төмрийн хүдэр импортолсон бол 2021 онд 1.12 тэрбум тонн төмрийн хүдэр импортолсон байна. Төмрийн хүдрийн импорт багасаж байгаа гол шалтгаан нь БНХАУ-д төмрийн хог хаягдлыг дахин боловсруулж хэрэглэх нь ихсэж байгаатай холбоотой бөгөөд 2022 онд нэмэгдэх төлөвтэй байгаа юм байна. Үүнтэй холбоотой 2022 онд төмрийн хүдрийн импорт 1.08 тэрбум ам.доллар хүрэх боломжтой байгааг Jinrui Capital-аас мэдэгдэж байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг яттасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Холбоо барих

Т.Азтүшиг
Ахлах шинжээч

aztushig@golomtcapital.com
9997-0303

Golomt Capital®